



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 11 өдөр

Дугаар 0/466

Арвайхээр сум

Үндэсний сурын харвааны цол
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 11 дүгээр зүйлийн 11.3, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102, Өвөрхангай аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн Үндэсний сурын харваанд эрэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын харьяат Мягмарсүрэнгийн Мандахбаяр, эмэгтэй төрөлд түрүүлсэн Баянхонгор аймгийн Заг сумын харьяат Алтан-Эрдэнийн Пүрэвжав нарт “АЙМГИЙН МЭРГЭН” цол.

2.Үндэсний сурын харвааны эрэгтэй төрөлд хоёрдугаар байр эзэлсэн Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын харьяат Мөнхтогтохын Мөнхбаатарт “АЙМГИЙН ГАРАМГАЙ ХАРВААЧ цол.

3.Үндэсний сурын харвааны өсвөр насны эрэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын харьяат Насан-Өлзийгийн Өлзийхишиг, эмэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Уянга сумын харьяат Гантөмөрийн Цэцэгмаа нарт “ӨСӨХ ИДЭР МЭРГЭН” цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0960

D:My Doc. Zahiramj. Zasag darga